



ОРХОН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 11


Эрдэнэт

┌ Одон, медаль болон үнэмлэхийг нөхөн
└ олгуулахаар уламжлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны “Зарлигт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 132 дугаар зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус III хуралдаанаас ТОГТООХ НЬ:

Баян-Өндөр сумын Булаг багийн иргэн Цэрэнгийн Өлзийбат нь 1965,1979 онд шагнуулсан алдарт эхийн 1,2-р зэргийн одон, Баян-Өндөр сумын Зэст багийн иргэн Намсрайжавын Пүрэвсүрэн нь 1981 онд шагнуулсан алдарт эхийн /131269 дугаартай/ 2-р зэргийн одонгийн үнэмлэх, Баян-Өндөр сумын Шанд багийн иргэн Данзангийн Галя нь 1978 онд шагнуулсан /28990, 73827 дугаартай/ алдарт эхийн 1,2-р зэргийн одонгийн үнэмлэх, Баян-Өндөр сумын Цагаанчулуут багийн иргэн Балчигийн Бумцэндийн /2009 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 167 дугаартай/ зарлигаар шагнуулсан Хөдөлмөрийн хүндэт медалийг тус тус түймэр болон хулгайд алдсан тул нөхөн олгуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ